



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А78

Чойбалсан

Г “ЭШ-2025” эрчимжүүлсэн сургалт, Т
үйл ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.3, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.8, 13 дугаар зүйлийн 13.1.6, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 03 дугаар хуралдааны 03/04 тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийн 2025 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 1.1.2, тус хуралдааны 03/04 дүгээр “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилийн төгсөх 12 дугаар ангийн суралцагчдыг сургууль төгсөх, их дээд сургуульд элсэх элсэлтийн шалгалтад бэлтгэх “ЭШ-2025” эрчимжүүлсэн сургалт зохион байгуулах болон элсэлтийн шалгалтад амжилт үзүүлсэн багш, суралцагч, сургалтын байгууллагыг урамшуулахад зориулан 50,200,000 (тавин сая хоёр зуун мянга) төгрөгийн төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

2.Холбогдох зардлыг аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 2.2 дахь “ЭШ-2025” эрчимжүүлсэн сургалт, амжилт үзүүлсэн багш, суралцагч, сургалтын байгууллагыг” зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3.Аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-тай байгуулах “Орон нутгийн төсөв”-өөс дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулан батлуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Нарангэрэл), Санхүү төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т тус тус даалгасугай.

4.Эрчимжүүлсэн сургалт болон амжилт үзүүлсэн суралцагч, багш, сургууль хамт олныг урамшуулах ажлыг зохион байгуулж, сургалтын явц, үр дүнг танилцуулахыг аймгийн Боловсролын газар (Ч.Ариунаа)-т, 12 дугаар ангийн суралцагчдын сургууль төгсөх болон их дээд сургуулийн элсэлтийн шалгалтын дундаж оноог өмнөх жилээс ахисан амжилт үзүүлж ажиллахыг ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

2125010163

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁЛ

Аймгийн Засаг даргын *М.С.* бны
02 дүгээр сарын *06*-ны өдрийн
1178 дугаар захирамжийн хавсралт

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТАД АМЖИЛТ ҮЗҮҮЛСЭН СУРАЛЦАГЧ, БАГШ,
СУРГУУЛИЙГ УРАМШУУЛАХ ТӨСӨВ

№	Урамшууллын төрөл	Тоо хэмжээ	Нийт үнэ
1.	Дээд амжилт үзүүлсэн сурагчдын урамшуулал /800 оноо авсан сурагч/	10 суралцагч	10,0 сая
2.	Судлагдахуун бүрээр амжилт гаргасан мэргэжлийн багшийн урамшуулал	26 багш	32,7 сая
3.	Элсэлтийн шалгалтын дүнгээ өмнөх жилээс ахиулсан сургууль 1-р байр	1 сургууль	2,5 сая
4.	Элсэлтийн шалгалтын дүнгээ өмнөх жилээс ахиулсан сургууль 2-р байр	1 сургууль	2,0 сая
5.	Элсэлтийн шалгалтын дүнгээ өмнөх жилээс ахиулсан сургууль 3-р байр	1 сургууль	1,5 сая
6	"ЭШ-2025" эрчимжүүлсэн сургалт зохион байгуулах явц болон элсэлтийн шалгалтад амжилт үзүүлсэн багш, суралцагч, сургалтын байгууллагын туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх	3	1,5 сая
Дүн			50,2 сая